

**Соёлын өвийн төвийн 2007 оны  
бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл  
ажиллагааны тайлан**

Уланбаатар хот  
2007 он

## Соёлын өвийн төвийн 2007 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны тайлан

### Бүтээгдэхүүний анги-1.1. Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр

Уг ажлын хүрээнд I,II улиралд багтаан доорхи ажлуудыг хийв.

1. Үндэсний хөтөлбөрийн 3.2.1 зорилтонд тусгагдсаны дагуу түүх, соёлын дурсгалт зүйл музейн үзмэрийн бүртгэлийн програм хангамжийг зохиох ажлыг II улиралд багтаан дуусгав.
2. Үндэсний хөтөлбөрийн 3.2.2 зорилтонд тусгагдсаны дагуу хөтөлбөрт хамрагдаж буй 35 байгууллагыг ТСДЗ-ийн бүртгэлийн програм хангамж бүхий компьютер дагалдах хэрэгсэл болон мэргэжлийн гэрэл зургийн аппарат, бусад тоног төхөөрөмжөөр хангав.
3. Үндэсний хөтөлбөрийн 3.2.3 зорилтонд тусгагдсаны дагуу програм хангамж, тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчинг бэлтгэхэд зориулсан сургалт зохион байгуулав.

#### Нэг. Програм хангамжийн талаар

Үндэсний хөтөлбөрийн 3.2.1 зорилтонд тусгагдсан програм хангамж бүтээх ажлын хүрээнд 3 төрлийн програм зохиохоор төлөвлөсөн юм.

1. Хөтөлбөрт хамрагдаж буй байгууллагад зориулсан-Харилцагчийн програм, Бүртгэл мэдээллийг нэгтгэн, боловсруулалт хийх-Мэдээлэл боловсруулах програм
2. Үл хөдлөх дурсгалыг бүртгэх програм
3. Утга соёлын өвийг бүртгэх програм

Хэрэглэгчийн болон мэдээлэл боловсруулах эхний програмыг II улиралд багтаан эцэслэн дуусгахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу -Хөтөлбөрт хамрагдаж буй 35 байгууллагын түүх, соёлын дурсгалыг бүртгэх **RCH 1.0 буюу Registration of Cultural Heritage** програм, -Ирүүлсэн бүртгэл мэдээллийг СӨУНБМСанд нэгтгэн боловсруулалт сервер хийх **СCH 1.0 буюу Cultural Center Heritage** програм хангамжийг зохиох ажлыг 2006 оны 8-р сард эхлэж, 2007 оны 5-р сарын 23-нд дуусган бэлэн болголоо.

БСШУ-ны сайдын 56 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Монгол улсын соёлын өвийн бүртгэл” Маягт №2-ийн загварыг үндэс болгон 33 өгөгдөлөөс бүрдсэн энэхүү програмын ажиллах зарчим, бодлогын даалгаврыг Соёлын өвийн төвөөс боловсруулан гаргаж, компьютерийн програм хангамжийн чиглэлээр ажилладаг “Сайбер-Андромедиа” ХХК-тай гэрээ байгуулан хамтарч гүйцэтгэлээ.

Програмын “Төрөл зүйл”, “Он цаг” гэсэн өгөгдлүүдэд бэлэн жагсаалт оруулахын тулд холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, музейн мэргэжилтнүүдтэй хамтран түүх, соёлын дурсгалын төрөлжүүлсэн ангилалт хийж, түүхэн он цагийн жагсаалт гаргалаа. “Зэрэглэл”, “Бүртгэлийн ангилал”-д Соёлын өвийг хамгаалах тухай хууль, музейн стандартад тусгасан ангилалыг оруулсан ба “УНБМСангийн дугаар”-т улсын хэмжээнд мөрдөгдөж буй шинэчилсэн бүс нутгийн код, индекс

ашигласан нь монгол улсын хууль, эрх зүйн орчинд бүрэн нийцсэн програм болж чадсан гэж үзэж болно.

Түүнчлэн програм нь Microsoft Word, Photoshop програм, интернеттэй уялдан ажилладаг, мэдээлэл нэгтгэх, хайх, боловсруулах ажиллагааг сайн гүйцэтгэх хамгийн сүүлийн үеийн компьютерийн програмчлалын хэл ашиглан бүтээсэн зэрэг олон давуу талтай.

RCH, CCH програмын үзүүлэлт:  
Бичигдсэн технологи: Microsoft .NET 2005  
Програмчлалын хэл: VB, C#, ASP.NET  
Өгөгдлийн бааз: Sql 2000  
Microsoft framework: version 2.0

Уг програм нь түүх, соёлын дурсгалын бүртгэл мэдээллийг интернетийн сүлжээ ашиглан дамжуулж байхаар хийгдсэн тул Үндэсний хөтөлбөрийн 4.4-т заасан интернэт ашигласан зардал болон бүртгэн баримтжуулах ажилд зориулсан тусгай зардлыг жил бүр тухайн байгууллагын төсөвт суулгах ажлыг улс, аймгийн бүх музей, байгууллагын хүрээнд шийдвэрлэлээ. 2007 онд интернэт ашиглах зардлыг хөтөлбөрт тусгагдсан төсвийн дагуу бүх байгууллагад 5-р сард шилжүүлэв.

Түүнчлэн эдгээр байгууллагуудыг [www.monheritage.mn](http://www.monheritage.mn) домайн хаяганд тулгуурласан интернэт хаягтай болгож мэдээллийг интернэтээр түргэн шуурхай дамжуулах нөхцөлийг бүрдүүллээ.

Хөтөлбөрт хамрагдаж буй байгууллагын үйл ажиллагааг гадаад дотоодод сурталчлан танилцуулах зорилгоор тухайн байгууллагын танилцуулга, нээлттэй зарим мэдээллийг багтаасан [www.monheritage.mn](http://www.monheritage.mn) вэб сайтын монгол тайлбар бүхий хувилбарыг хийж байна.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх дараагийн програм хангамж нь “Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах програм” болон утга соёлын өвийг бүртгэх зориулалттай юм. Энэ оны 10-р сард дээрх хоёр програм хангамжийн бодлогын даалгаврыг хийж, програмыг 2008 оны 3-р сард дуусгахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

- ШУА-ийн харъяа Археологийн хүрээлэн болон бусад их, дээд сургууль, судалгааны төвийн судлаачидтай хамтран “Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалын төрөлжүүлсэн ангилалт”-ыг гаргаж, бүртгэлийн маягт, бүртгэлийн програм хангамжийн бодлогын даалгаварт саналуудыг тусган оруулсан.

-Үл хөдлөх дурсгалын бүртгэлийг хийх тусгай Маягт №1-ийг боловсруулан БСШУ-ны сайдын 10-р сарын 04-ний өдрийн 348-р тушаалаар батлуулан програм хангамжинд ашиглаж байна.

Утга соёлын өвийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг бэлтгэх, програм хангамжийн бодлогын даалгавар боловсруулах талаар ажиллаж байгаа ба утга соёлын өвийн бүртгэн баримтжуулсан хэрэглэгдхүүний нэг хувийг Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалуулахаар тохиролцоод байна.

Хоёр. Техник, тоног төхөөрөмжөөр хангасан талаар

Үндэсний хөтөлбөрийн зорилтын 3.2.2-д тусгагдсаны дагуу хөтөлбөрт хамрагдаж буй 35 байгууллагыг компьютер, гэрэл зургийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг II улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан, 35 байгууллагуудад суурилуулах Athena 306 P mimitower компьютер, тог баригч UPS, Samsung 3 үйлдэлт принтер бүхий тоног төхөөрөмжийг “ЭМ СИ ЭС электроникс” ХХК барааг нийлүүлэх сонгон шалгаруулалтанд ялж 2007 оны 6-р сарын 05-ны өдөр хүлээн авсан.

Гэрэл зургийн мэргэжлийн аппарат хэрэгслэл, тоног төхөөрөмжийг нийлүүлэх тендер 3-р сараас хойш 3 удаа зарлагдан 6-р сард “Номин электроникс” ХХК нийлүүлэх эрхийг авч гэрээ байгуулан 8-р сард 10.1 мега пиксель бүхий мэргэжлийн гэрэл зургийг Канон дижитал аппарат, хоёр төрлийн дуран, гэрэл зургийг жижиг студи зэрэг 14 нэр төрлийн барааг нийлүүлсэн.

Техник хэрэгсэл бүрэн нийлүүлэгдсэний дараа 8-р сараас 12-р сар хүртэл манай мэргэжилтнүүд хөтөлбөрт хамрагдаж байгаа 21 аймаг, нийслэлийн нийт 35 байгууллагад очиж техник хэрэгслэлээ суурилуулан, компьютеруудад RCH програм хангамжийг суулгаж, интернэтийг ашиглалтанд оруулах ажлыг хийж байгууллага тус бүртэй “Бүртгэл ирүүлэх тухай гэрээ”, “Тоног төхөөрөмжийг ашиглах тухай гэрээ” гэсэн хоёр төрлийн гэрээг байгуулав.

Зарим байгууллагын онцлогоос хамаарч дурсгалыг бүртгэх төрөл, зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг тогтоож 2008 оны эхний улиралд нэмэлт хийхээр төлөвлөв.

Үндэсний хөтөлбөрийн 4.5-д тусгагдсан Улсын нэгдсэн нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэлийг хадгалах архивын зориулалттай тоноглогдсон өрөө бий болгох ажил хийгдэж, бичиг хэргийн ширээ, шкаф, негатив, CD хийх шүүгээ сав, архивын зориулалттай хадгаламжийн гүйдэг сейф хүлээн авч тохижуулах ажлыг “Цөм трейд” ХХК, “New boss” ХХК, “ПДМС” ХХК-тай хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай монгол улсын хуулийн 8-р зүйлийн 1.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт явуулж хийгээд байна.

### Гурав. Сургалт зохион байгуулсан талаар

Үндэсний хөтөлбөрийн 3.2.3 зорилтонд тусгагдсаны дагуу бүртгэл хийх арга зүй, компьютер, програм хангамжийг ажиллуулах боловсон хүчнийг бэлтгэхэд зориулсан сургалт семинарыг II улиралд зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 6-р сарын 11-нээс 15-ны өдрүүдэд “Хүүхдийн номын ордон”-ы уншлагын танхимд зохион байгууллаа.

Хөтөлбөрт хамрагдах 35 байгууллагаас бүртгэн баримтжуулах ажлыг гүйцэтгэх чадвартай, наад зах нь 5 доошгүй жил тогтвор сууршилтай ажиллах итгэмжлэгдсэн 2 хүний нэрсийг 3-р сард авч 68 хүний нэрс ирсэн. Эдгээрийн 64 нь семинарт оролцсон. ШУА-ийн харъяа Археологийн хүрээлэн, Палеонтологийн төвийн ажилтнууд 6-р сард хээрийн судалгааны ажлаар явж, 10-р сард сургалтанд хамрагдсан.

Гандантэгчинлэн хийдээс оролцох ёстой 2 хүн огт ирээгүй. Дашрамд тэмдэглэхэд манай орны түүхийн дурсгалын арвин их сан хөмрөг Гандантэгчинлэн хийд хадгалагдаж байдаг боловч бүртгэл,

хадгалалт хамгаалалт хангалтгүй байдгаас алдагдах үрэгдэх явдал багагүй гардаг. Энэхүү нөхцөл байдал харгалзан “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн биелүүлэх үүднээс тус байгууллагыг үндэсний хөтөлбөрт оролцуулахаар тогтсон билээ. Гэвч тус байгууллага нь энэ ажилд бага ач холбогдол өгч байгаа учир БСШУ-ны яамнаас албан ёсоор мэдэгдэж идэвхтэй оролцох талаар сануулга өгөн бидний ажилд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Үндэсний хөтөлбөрт хамрагдаж буй байгууллагуудын албан хэрэгцээнд зориулсан бүртгэл хийх тухай гарын авлага, товхимолыг семинараас өмнө бэлтгэв.

Энэхүү товхимолд:

- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө, хөтөлбөрт хамрагдах байгууллагын үүрэг зэргийг тусгасан танилцуулга
- Үндэсний түүхийн музей, Палеонтологийн төв, Утга соёлын өвийн үндэсний төв, Байгалийн түүхийн музей, Богд хааны ордон музей, Үндэсний номын сангийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай хамтран боловсруулсан түүх, соёлын дурсгалыг бүртгэх арга зүй, угсаатны зүй, чулуун эд зүйл, палеонтологи, археологийн олдвор, утга соёлын өв, үл хөдлөх дурсгал, байгалийн дурсгал, ном судар, гурван хэмжээст болон дэлгэмэл бүтээлийг бүртгэхэд юуг анхаарах, эдгээр нь дотроо ямар төрөл зүйлд ангилагддаг болон түүхэн хөгжил, онцлог шинжийг тайлбарласан удирдамж, зааварчилгаа
- Мөн товхимолд дурсгалыг гэрэл зургаар баримтжуулах заавар
- Түүх, соёлын дурсгалыг бүртгэх RCH програмын зааварчилгаа багтсан бөгөөд нийт 71 хуудастай, өнгөт гэрэл зурагтай, А4-ийн хэмжээтэй товхимол болж 80 ширхэг хувилан, бүрэн тараагдаж дууссан байна.

Семинарын хичээлийн хуваарь, хичээлийн байрыг бэлтгэх болон оролцох хүмүүсийг байрлуулах буудал, өдөр, орой хооллох газрыг урьдчилан судлан тохиролцож төсвийн дагуу зардлыг нарийн тооцоолон хувиарласан.

Семинар дээр бүртгэн баримтжуулах онол, арга зүйн 9 төрлийн хичээл болон RCH програм дээр ажиллах дадлага хичээл орсон. Онол, арга зүйн хичээлийг сонирхолтой байлгах үүднээс компьютер ашиглан дүрст хичээл хэлбэрээр бэлтгэж, эрдэс судлаач, эрдэмтэн професор Г.Гонгоржав, ШУА-ийн Палеонтологийн төвийн эрхлэгч Х.Цогтбаатар, Байгалийн түүхийн музейн ЭШ-ний тасгийн эрхлэгч Н.Жавзмаа, Утга соёлын үндэсний төвийн захирал Юндэнбат зэрэг найман багш, манай мэргэжилтэнгүүдтэй хамтран явууллаа.

RCH програм дээр ажиллах дадлага хичээлийг урьдчилан суурилуулж бэлтгэсэн 24 ширхэг компьютер тоног төхөөрөмж ашиглан явуулсан. Уг хичээлийг манай байгууллагын програмист зааж, “Сайбер-Андромедиа” ХХК-ийн програмын баг туслалцлаа.

RCH програмыг зааварчилгааг 2 янзаар бэлтгэсэн.

1. Уншиж судлах товхимол хэлбэрээр- Энэ нь сургалтанд зориулсан гарын авлага дотор багтсан,

2. RCH програм хангамжийн Help дотор нь видео хичээл хэлбэрээр бэлтгэн, дадлага хичээл зааснаар RCH програм хангамжийг эзэмших бүх нөхцөл хангагдсан гэж үзэж байгаа юм.

### **Бүтээгдэхүүний анги-1.2. “Монгол дахь буддын урлаг” каталог хэвлүүлэх ажил**

Англи дахь Төвдийн сантай хамтран Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Эрдэнэ зуу музей, Данзанравжаагийн музейд хадгалагдаж буй шилмэл танка зураг, зээгт наамал, тиг, барын зургийн 441 бүтээлээс бүрдсэн “Монгол дахь буддын урлаг” нэртэй каталоги хэвлүүлэх ажлыг 2003 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ жилдээ багтаан дуусгахаар төлөвлөөд байгаа юм. Одоогийн байдлаар каталогид орсон 441 бүтээлийн монгол, англи тайлбар текстийн эцсийн шатны хяналтанд орж дууссан. Номын оршил, үгийн тайлбар /glossary/ мөн бэлэн болоод байна.

Төвдийн сангаас баталсан загвар макетын дагуу “Эх бэлтгэх” ажлыг 8-р сар эхлүүлж, каталогид орох бүтээлийн гэрэл зургийг хянах, компьютерт оруулан ажлыг дуусгаад байна.

Англи дахь төвдийн сан, Тайланд улсын хэвлэлийн “Сериндиа” компанитай гэрээ байгуулан каталогийг 2008 оны 3-р сард хэвлэж нийтийн хүртээл болгохоор гэрээ байгуулсан. Энэ каталогиноос 500 ширхэг нь монгол улсын бүх номын сан, музейд үнэ төлбөргүй тараагдана.

### **Бүтээгдэхүүний анги-1.3. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэх хэтийн төлөвлөгөө зохиох**

1998 онд батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тухай БСШУЯамны 2006 оны 6-р сарын 30-ны өдрийн хурал, Монгол улсын Засгийн газрын 2006 оны 10-р сарын 04-ний өдрийн хуралдааны 43-р тэмдэглэлд уг хөтөлбөрийг аялал жуулчлал, дэд бүтэцтэй холбон шинэчлэн боловсруулах нь зүйтэй гэж үзсэн.

Ажлын хэсэг “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг боловсруулахдаа Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.1, 17.9 дэх заалтуудын дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын эрхлэх ажлын хүрээнд тэдний үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлэх, Хөтөлбөрийн үндэслэл, түүний эрх зүйг томъёолж, хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, санхүүжилт, төсөвт өртөг, хугацаа, гарах үр дүн, шалгуур үзүүлэлт зэргийг нь тодорхойлон хөтөлбөрт тусгасан. Тухайлбал, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааны төлөвлөлтийг “Сэргээн засварлах дурсгалууд; консерваци хийж, бэхжүүлж хамгаалах дурсгалууд; хэв, дардас авах, хуулбар хийх дурсгалууд; унаган газраас Улаанбаатарт зөөж хадгалах дурсгалууд; аялал жуулчлалын бүс нутаг, чиглэлд хамрагдах дурсгалууд; Соёлын өвийг хамгаалах сургалт, сурталчилгааны ажлууд”, “Соёлын өвийн төвийг өргөжүүлэх” гэж долоон чиглэлээр 2008-

2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн түүнд 13498.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газар 2007 оны 11-р сарын 21-ний өдрийн 303-р тогтоолоор баталсан.

#### **Бүтээгдэхүүний анги-1.4. Түүх, соёлын ердийн дурсгалд гэрчилгээ олгох**

2007 оны 5-р сар хүртэлх хугацаанд иргэдийн гар дээр байгаа 700 эд өлгийн зүйлд “Түүх, соёлын ердийн дурсгалт зүйлийн гэрчилгээ” олгогдожээ.

2007 оны 5-р сарын 03-ны өдөр Түүх, соёлын дурсгалт зүйлд зэрэглэл, үнэлгээ тогтоох Мэргэжлийн зөвлөл хуралдаж түүх, соёлын ердийн дурсгалт зүйлд олгогдож буй гэрчилгээ, түүний хавтгайралт, улс, аймгийн музейн сан хөмрөгт тооллого болох гэж байгаатай холбогдуулан хил гаалиар түүх, соёлын дурсгалыг гаргах тухай ярилцлага хийж, түр хугацаагаар гэрчилгээ өгөх ажлыг зогсоосон.

#### **Бүтээгдэхүүний анги-2.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээ**

Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээнд энэ жил 12 музейн 180 орчим үзмэрт үзүүлэхээр төлөвлөжээ.

2007 оны эцэст 13 музейн даавуу, мод, цаасан шуумал, шавар болон алт мөнгө метал эдлэл бүхий 220 ширхэг үзмэрийг сэргээн засварлаад байна. Үүнд: Үндэсний түүхийн музейн малгай, дээл, гутал, сав, суулга гэсэн угсаатны зүйн эдлэл болон археологийн олдвор болох үйсэн сав, дээл, сав суулга, алт мөнгөн эдлэл нийт 22 үзмэр, Богд хааны ордон музейн VIII Богдын эдлэж хэрэглэж байсан 18 ширхэг модон тавилгууд зэрэг бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсан ажлаас гадна гадаад, дотоодод үзэсгэлэн гаргахад зориулсан нэмэлт үзмэрийн сэргээн засварлалт ажил хийгдлээ.

Испани улсад зохиогдох “Монголын нэг өдөр” үзэсгэлэнд явах Дүрслэх урлагийн музейн цамын баг, додиг, модиг, дээл, Сүхбаатар аймгийн музейн дарьганга, халх эхнэрийн иж бүрэн хувцас чимэглэл, Булган, Завхан, Хөвсгөл, Увс аймгийн нийт 50 орчим үзмэрт анхан болон дунд шатны цэвэрлэгээ бөхөлгөө, оёдол, мод, арьсан эдлэлийн сэргээн засварлалт хийжээ.

Чойжин ламын сүм музей дээр очиж ажиллан Найдан жүдэг, Махранз, Гомбо бурхан, Дамдинчойжоо бурханы шавар, шуумал хөргүүдийг сэргээн засварлаж, металл бүтээлүүдэд засвар хийлээ.

#### **Бүтээгдэхүүний анги-2.2. Нурж буй сүмийн хананд байгаа 18-р зууны үед холбогдох бурханы шашны зургийг авран хамгаалах ажлыг төсөл боловсруулан хэрэгжүүлэх.**

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт байдаг 18-р зууны үед баригдсан Чин сүжигт номун хааны хийдийн дэргэдэх эвдэрч нурсан сүмийн 2 хананд буй 4х2 м хэмжээтэй “Ганзай” зургийг сэргээн засварлан Дүрслэх урлагийн музейд байруулах ажлыг гурван үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Уг төслийн эхний шатны ажил болох ханын зургийг буулган зөөвөрлөн тээвэрлэж авчрах ажлаар захирал Г.Энхбат, 4 сэргээн

засварлагч, үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг 6-р сарын 16-наас 25-ны хооронд Чин сүжигт номун хааны хийд дээр очиж ажиллалаа. Ажлын үйл явцыг дараах шатлалаар хэрэгжүүллээ. Үүнд:

-Чин сүжигт номун хааны хийдийн дэргэдэх эвдэрч нурсан сүмийн 2 хананд буй 4x2 м хэмжээтэй бурханы шашны танка зургийн нэгэн төрөл “Ганзай” зургийг дарж будаж шохойдсоныг арилган цэвэрлэж, зургийг Паралойд В72, 5%-ийн найрлагатай тусгай бодисоор бэхжүүллээ.

- Зургийг гэмтээлгүй буулган авах үүднээс дээр нь тусгай цавуутай даавуу наасан.

-Үүний дараа зургийг нураахгүй авч болох хэсгээр нь зүсэлт хийж, ханын өнгөн шаврын хамт зургийг хуулан авах ажлыг хийлээ.

-Хуулсан зурагтай шавар бэлдэцүүдээ тусгай бэлтгэн авчирсан хавтгай модон хайрцагнуудад хамгаалалт хийн гэмтээлгүй өрж хийсэн.

Зургийг засаж янзлан, шороо тоосноос цэвэрлэн, жигд гадаргуу үүсгэх, хагархай цоорхой хэсгийг нөхөх, өнгө будгийн засвар хийлгүйгээр зургийн дүрслэл өнгийг хадгалагдан үлдсэн чигт нь бэхжүүлж, хамгаалалтыг хийж, тусгай жаазанд байрлуулан 12-р сард Дүрслэх урлагийн музейн эртний урлагийн танхим, сан хөмрөгт шилжүүлж өглөө.

### **Тусгай захиалагт бүтээгдэхүүн**

### **Бүтээгдэхүүний анги-1.1 Улсын хэмжээний музейн үзмэрийн тооллого явуулах үйл ажиллагаа**

Энэ ажлын хүрээнд:

- Улс, аймгийн музейнүүдэд улсын тооллогыг чанартай, үр дүнтэй явуулахад шаардагдах төсөв хөрөнгийг Сангийн яам, БСШУЯамтай хамтран шийдвэрлэсэн ба 2007 оны төсвийн тодотголоор хадгалагдаж буй үзмэрийн тооноос хамаарч улсын болон аймгийн музейнүүдэд 145.0-944.5 мянган төгрөгний төсвийг хувиарлаж олгосон.
- Улсын тооллогоор бүртгэл хөтлөх тусгай шифр дугаар бүхий “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийг нэгдсэн журмаар хэвлүүлэн музейнүүдэд тараасан.
- Үзмэр, эд зүйлийг үнэн бодитойгоор жинлэн хэмжихэд зориулан 2 төрлийн электрон жин хэмжүүрийг (Улсын стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан, 0-30 кг хүртэл, 0-100 кг хүртэл хэмжих) музейнүүдэд хүлээлгэн өгсөн.
- Одоо мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актууд, шинээр батлагдсан музейн стандартад нийцүүлэн Улсын тооллого явуулах удирдамж,
- Улсын тооллогын үеэр хөтлөх “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийн загвар (Маягт №1)
- “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлээс хасах зүйлийн жагсаалт” (Маягт №2)
- “Хулгайд алдагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл” (Маягт №3),
- “Дутсан, солигдсон үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл” (Маягт №4),
- “Сүм хийд, бусад байгууллагад гэрээгээр эзэмшүүлж буй үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл”-ийг (Маягт №5) боловсруулан 2007 оны



10-р сарын 03-ний өдрийн “Улс, аймгийн музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах тухай” 345-р тушаалыг батлуулав.

- Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогыг явуулахтай холбогдуулан музейн ажилтнуудад зориулсан сургалт семинарыг 2007 оны 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Уран зургийн галерейд зааланд зохион байгуулсан. Сургалтанд улсын тооллого явагдах 34 музей (байгууллага)-н ажилтнууд болон улсын болон аймгийн мэргэжлийн хяналтын байцаагч нар оролцсон.
- Улсын тооллого явуулахад холбогдох хууль эрх зүйн акт баримт, тооллогын бүртгэлийн дэвтрийг хөтлөх заавар бүхий авлага материалыг хэвлүүлэн, музейнүүдэд тараасан.

### **Улсын тооллогын явц**

БСШУЯамны Сайдын баталсан тушаалын дагуу Улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2007 оны улсын тооллогыг 2007 оны 10 дүгээр сарын 15-нд улс, аймгийн 34 музей /байгууллага/-д нэгэн зэрэг эхлэн явагдаж байна. Энэ удаагийн музейн сан хөмрөгийн улсын тооллого 2008 оны 3 улирлыг дуустал явагдах юм.

Тооллогын үеэр музейнүүдээс гарч буй санал асуудлыг Улсын тооллогын төв комисс хүлээн авч, дор бүр нь шийдвэрлэн ажиллаж байна.

УНБМСангийн мэргэжилтнүүд болон төв комиссын гишүүд музейнүүд дээр биечлэн очиж ажиллаж байгаа бөгөөд Ш.Энхтуяа 2 удаа Эрдэнэ зуу музей рүү, Б.Даваацэрэн Дундговь аймагт тус тус томилолтоор ажиллалаа.

Улсын тооллого явагдахаас өмнө “Соёлын өвийг тоон системд оруулан хадгалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд музейнүүдэд гэрэл зургийн иж бүрэн студи, компьютер тараасан нь тооллогын үеэр үзмэрийн гэрэл зургаа баримтжуулан авахад ихээхэн тус дөхөмтэй ажил болж байна.

### **Тусгай захиалагт бүтээгдэхүүн**

#### **Бүтээгдэхүүний анги-1.1 “Хөшөө цайдамын дурсгал”-ыг бүртгэн баримтжуулах**

Монгол Туркийн хамтарсан түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын хүрээнд Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших “Хөшөө цайдамын дурсгал”-ыг бүртгэн баримтжуулах, хамгаалах ажлыг 5-р сард хийхээр төлөвлөсөн боловч тэнд баригдаж буй музейн барилга ашиглалтанд ороогүй, зарим бэлтгэл ажил хангагдаагүй шалтгаанаар хойшлогдсон.

### **Бусад ажил. Ажилтнуудынхаа мэдлэг боловсролыг дээшлүүлсэн талаар**

Байгууллагын ажилтнуудаас мэдлэг боловсролоо дээшлүүлэх англи хэлний курст 5 хүн хамрагдаж, доктрантурын сургалтанд 2 хүн сурч байна.

6-р сарын 21-23-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Өндөрхаанд болсон “Зүүн бүсийн соёлын ажилтны анхдугаар зөвлөлгөөнд” үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн оролцож “СӨУНБМСангийн үйл ажиллагаа, үл хөдлөх дурсгалыг хамгаалах тухай” илтгэл тавьлаа.

Үндэсний архивын газраас зохион байгуулсан “Архивын баримтын тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт”, “Архивын баримтын эрэлт хайлт, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх” 32, 40 цагийн сургалтанд мэргэжилтэн Ш.Энхтуяа, Д.Нарантуяа, М.Дэжид нар оролцлоо.

UNESCO, ICCROM-оос зохион байгуулсан “Бөс даавуун эдлэлийн урьдчилсан хадгалалт хамгаалалт” сэдэвтэй сургалт семинарт сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн, Г.Гантуяа нар оролцлоо.

Бүртгэл мэдээллийн сангийн мэргэжилтэн Ш.Энхтуяа 10-р сарын 1-нээс 11-р сарын 15 хүртэл Энэтхэг улсын Дели хотод олон улсын ИТЕС – ийн байгууллагын шугмаар англи хэлний сургалтанд хамрагдлаа.

8-р сарын 1-15-ны хооронд Хятад улсын Бээжин хотод болсон “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын менежмент” олон улсын сургалтанд Бүртгэл-мэдээллийн сангийн мэргэжилтэн Д.Нарантуяа оролцлоо.

10-р сарын 1-7-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Монголын урлагийн зөвлөл, Монгол дахь UNESCO-ийн салбар зөвлөл хамтран зохион байгуулсан “Музейн аюулгүй байдал ба маркетинг” сэдэвт сургалт семинарт захирал Г.Энхбат, Бүртгэл-мэдээллийн сангийн мэргэжилтэн Д.Нарантуяа оролцлоо.

БНХАУ-ын Соёлын буцалтгүй тусламжаар Богд хааны ордон музейн Гол хаалгыг сэргээн засварлах ажлын хүрээнд сэргээн засварлагч Г.Соёл-Эрдэнэ, Д. Ууганчимэг нар БНХАУ-ын улсын Си-ань мужийн сэргээн засварлах газарт сүм хийд уран барилгын чимэглэлийн ханын зургийн чиглэлээр 2007 оны 11-р сарын 20-ноос 2008 оны 1-р сарын 20 хүртэл 2 сарын хугацаатай дадлагажигчаар ажиллаж суралцаж байна.

БНХАУ-ын Бээжин хотын музей, Бээжин хотын нандин зүйлийг судлах төв, Хааны ордны шинжлэх ухааны хэлтсийн сэргээн засварлах ажил, түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах ажилтай танилцах, туршлага судлах чиглэлээр бүх ажилтнууд 2007 оны 11-р сарын 24-нөөс 11-р сарын 30-ний өдрийг хүртэл Бээжин хотод ажиллалаа. Энэхүү дадлагажилтын ажилд манай байгууллага бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан бөгөөд маш үр дүнтэй ажил болсон гэж үзэж байгаа юм.

## **2007 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдаагүй, нэмэлт ажлууд**

1. Дэлхийн хөшөө дурсгалын сантай хамтран Богд хааны ордон музейн Найдан сүмийн барилгын гадна чимэглэлийг бэхжүүлж сэргээн засварлах, зарим судалгаа хийх ажлыг Австри улсын сэргээн засварлагчтай хамтран хийв. 2007. 7- 8 сар
2. БНХАУ-ын Соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд Хятадын Си-Ань мужийн сэргээн засварлах төвтэй хамтран Богд хааны ордон музейд сэргээн засварлах ажлыг хийв.

2007. 7-9 сар

3. Казахстан улсын сэргээн засварлагчтай хамтран Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших Тоньюкукын гэрэлт хөшөөнөөс хэв авах ажлыг хамтран гүйцэтгэв.

2007. 8 сар

4. Дорнод аймгийн Сүмбэр сумын Их бурхантын цогцолбор дурсгалыг сэргээн засварлах ажилтай холбогдсон, гэмтэл бохирдлын тодорхойлолт, судалгааны ажлыг газар дээр нь очиж хийж дүгнэлт гарган, сэргээн засварлах ерөнхий төсөв тооцоог Дорнод аймгийн ЗДТГазар, музейн захиалгаар хийв.

2007 .9-10 сар

5. Туркийн сэргээн засварлагчтай хамтран Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Хөшөө цайдамын цогцолбор дурсгалд хөшөө чулуу сэргээн засварлах, хуулбар хийх, шилжүүлэн байрлуулах ажлыг хийж гүйцэтгэв.

2007.6-9 сар

6. УМХГазрын соёлын улсын ахлах байцаагчтай хамтран Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутагт байгаа үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцан бүртгэн баримтжуулж, соёлын өвийн бүртгэлийг сум орон нутагт хэрхэн хөтөлж байгаатай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргасан.

2007 оны 9 сар

7. УМХГазар, БСШУЯамтай хамтран түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалагч аймаг, сумдын байгаль хамгаалагч нарт зориулсан гарын авлагын эхийг бэлтгэв.
8. Монголын урлагийн зөвлөлөөс эрхлэн гаргаж буй “Миний түүх, миний соёл” нэртэй 5 цуврал CD-ний текстэнд хяналт хийж, хамтран оролцов.
9. Монголын Үндэсний түүхийн музейн сан хөмрөгч Б.Энхбаттай холбогдох эрүүгийн 20706460 тоот хэрэг үүссэнтэй холбогдуулан БСШУ-ны сайдын 299 тоот тушаал гарч, тус музейн сан хөмрөгт хяналтын тооллогохийх ажлыг УМХГазар, Эрүүгийг цагдаагийн газартай хамтран хийж гүйцэтгэв.

2007 оны 9-10 сар

### **Ажилтнуудын нийгмийн асуудлын талаар.**

- Сэргээн засварлагч нарт химийн бодис, будаг, тоос шороо, тоосонцороос хамгаалах, саармагжуулах зорилгоор өдөрт 1 удаа 500 грамм хэмжээтэй амин дэм, сүү цагаан идээгээр хангаж байна.
- Сэргээн засварлагч нарт хөдөө хээрийн нөхцөлд ажиллах ажлын хувцас, малгай, бээлий, амны хаалт, сэргээн засварлах студид ажиллах хормогч, өвдөг, гарны хамгаалалт зэрэг хувцсаар хангаж байна.
- Өрх гэр толгойлж буй эмэгтэй, нийгмийн халамж хүссэн 8 ажилтанд 1,8 сая төгрөгний нэг удаагийн буцалтгүй тусамж олголоо.